

ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧИД ҮНЭМЛЭХ ОЛГОХ ШАЛГАЛТЫН

АРГА ХЭЛБЭР, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СОРИЛ

2024 ОНЫ 4-Р УЛИРАЛ

Шалгалтын зорилго:

Аялал жуулчлалын тухай хуулийн 10.4 болон Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам -ын 3.4-д заасныг үндэслэн жуулчны хөтөч- тайлбарлагчийн эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг үнэлж, цаашид мэргэжлийн үнэмлэхтэй болгоход тус шалгалтын зорилго оршино.

Дээрх зорилгын хүрээнд “Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмын 3.9-д заасны дагуу шалгалт нь Ур чадварын шалгалт (Нийт онооны 50 хүртэл хувь), Ерөнхий мэдлэгийн шалгалт (Нийт онооны 50 хүртэл хувь) гэсэн 2 үе шаттай бөгөөд Ур чадварын шалгалтад 60 болон түүнээс дээш оноо авч тэнцсэн шалгуулагч 2-р үе шат болох Ерөнхий мэдлэгийн шалгалтад хамрагдсан.

1. **Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийг** Монголын Үндэсний музей болон Чингис хаан Үндэсний музейд шалгуулагч тус бүрд дараах үзмэрүүдээс 2-ыг сонгон, гадаад хэлээр тайлбарлуулж үнэллээ.

Чингис хаан Үндэсний музейд

Гуравдугаар давхар. Эртний төрт улсын танхим

- Буган чулуу (буган чулуудаас өөрсдөө сонгож болно.)
- Ноён уулаас олсон Хүннү ширдэг
- Хүннүгийн үеийн хос мөнгөн луу
- Хүйс толгойн бичээс бүхий гэрэлт хөшөө

Дөрөвдүгээр давхар. Монгол нутаг дах эртний нүүдэлчдийн төрт улсын танхим

- Билгэ хааны алтан титэм
- Нэхмэл чимэгтэй арьсан гутал (Adidas гэж алдаршсан)
- Дугуй цахирын агуйгаас олдсон эсгий дээл

Тавдугаар давхар. Их монгол улсын танхим

- Чингис хааны хөрөг
- Алтан гэрэгэ
- Адууны шүдээр чимэглэсэн эмээл

Монголын Үндэсний музейд

Нэгдүгээр давхар. Эртний улсуудын танхим

- Келтигиний гэрэлт хөшөө
- Алтайн ятга

Хоёрдугаар давхар. Уламжлалт хувцас, гоёл чимэглэлийн танхим

- XVII-XX зууны монгол язгууртан эмэгтэйн хувцас, хэрэглэл
- Хөөрөг

Гуравдугаар давхар. Эзэнт гүрний танхим

- Чингисийн чулууны бичиг
- Юан гүрний үеийн торгон дээл

Гуравдугаар давхар. Уламжлалт соёлын танхим

- Морин хуур
- Амарбаясгалант хийдийн цогчин дуганы загвар

Гуравдугаар давхар Уламжлалт ахуйн танхим

- Хөхүүр
- Монгол гэр

Ингэхдээ тухайн шалгуулагч хөтөч-тайлбарлагчийн

Хөтөч тайлбарлагчийн техник эзэмшсэн байдал

- Зочдод тайлбарлахдаа ярианы хурдаа тохируулж, үг хэллэгээ тод хэлж, дуу хоолой далайцтай байж, зочидтой холбоо тогтоож чадаж буй эсэх
- Музейн аяллын үед үзмэрээс үзмэрт шилжих үед шат, босго, халтиргаа гулгааг сануулж, зочдыг аюулгүй аялахад анхаарал тавьж буй эсэх, мөн группыг оновчтой байрлуулж, хүн тус бүрд анхаарал хандуулж, сонор сэрэмжтэй байгаа эсэх,
- Асуултад техникийн дагуу товч тодорхой хариулж буй эсэх,
- Шалгалтын үеэр цэвэрхэн хувцаслаж, биеэ соёлтой авч явж, бусаддаа төвөг удахгүй хүндэтгэлтэй хандаж, хоцролгүй ирж, мэргэжлийн хандлага харуулж чадаж буй эсэхийг онцгойлон шалгана.

Мэдээлэл хүргэх чадвар эзэмшсэн байдал

- Өгөгдсөн хугацаанд гол мэдээллийг сонирхолтой байдлаар, хэлний оновчтой үг хэллэг, дүрэм ашиглан ярьж буй эсэх,
 - Тайлбарыг уялдаа холбоо, цэгцтэйгээр бодит тоо баримт, сонирхолтой жишээ, судалгаагаар баяжуулан хүргэж буй эсэхийг үндсэн шалгуур болголоо.
2. **Ерөнхий мэдлэгийг сорихдоо** доор дурдсан агуулгыг багтаасан 50 сорил бүхий, тус бүр 5 хариулттай сорил бэлтгэн шалгалаа. Шалгалтын сорилыг, оновчтой хариултын хамт доор хавсаргав.
- Түүх, археологи (тестэд эзлэх хувь 20)
 - Шашин, соёл (тестэд эзлэх хувь 20)
 - Газарзүй, геологи, палеонтологи, амьтан, ургамал (тестэд эзлэх хувь 20)
 - Монгол орны нийгэм, улс төр, эдийн засаг (тестэд эзлэх хувь 20)
 - Салбарын хууль эрх зүйн орчин, мэргэжлийн ёс зүй (тестэд эзлэх хувь 20)

САЛБАР: Аялал жуулчлал

МЭРГЭЖИЛ: Жуулчны хөтөч тайлбарлагч

ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 60 минут

ОНОО: 50

**ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧИД ҮНЭМЛЭХ ОЛГОХ ШАЛГАЛТЫН 2-Р ҮЕ ШАТ
ЕРӨНХИЙ МЭДЛЭГИЙН СОРИЛ**

2024 ОНЫ 4-Р УЛИРАЛ

Шалгуулагчийн нэр Шалгуулагчийн код:|_|_|_|_|_|_|_|_|_|

Даалгавар гүйцэтгэх удирдамж заавар:

Асуулт бүрийг анхааралтай уншиж гүйцэтгэнэ үү. Бүх асуулт 5 сонголтот хариулттай бөгөөд зөвхөн нэг хариулт нь оновчтой. Оновчтой хариулт бүр 1 оноо. Алдаатай хариултад оноо тооцохгүй. Амжилт хүсье.

1-Р ХЭСЭГ. ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН АСУУЛТ (ТЕСТЭД ЭЗЛЭХ ХУВЬ 20)

1. Буган чулуун хөшөөний үүрэг, зориулалт нь юу вэ?
 - А. Бэлэг эрхтэнтэй тун төстэй, үржлийн бэлгэдэлтэй холбоотой.
 - Б. Нэр хүндтэй дайчин, язгууртан, нийгмийн дээд давхрагын гишүүдэд зориулсан.
 - В. Оршуулгын чулуу
 - Г. Бүгд зөв
 - Д. Бүгд буруу
2. Хубилай хааны дийлж чадаагүй дотоодын дайсан нь хэн байсан бэ?
 - А. Хайду ноён
 - Б. Аригбөх хаан
 - В. Наян жанжин
 - Г. Алгу хаан
 - Д. Ли Сиэн
3. Хэрэйд, Найман зэрэг аймгууд ямар итгэл үнэмшилтэй байсан бэ?
 - А. Бөө мөргөл
 - Б. Исламын шашин.
 - В. Манихейн ёс.
 - Г. Христ
 - Д. Буддын шашин
4. Чингис хаан улсаа нэгтгэснийхээ дараа аль руу нь хамгийн түрүүнд довтолсон бэ?
 - А. Алтан улс.
 - Б. Тангуд улс
 - В. Сүн улс
 - Г. Дали улс
 - Д. Хорезм
5. Атилла хааны эзэнт улс аль улсаар төвлөрч байсан бэ?

- А. Унгар
 - Б. Герман
 - В. Орос
 - Г. Франц
 - Д. Турк
6. 2011 онд Булган аймгийн Баяннуур сумын Шороон бумбагараас олдсон олдвор аль үед хамаарах вэ?
- А. Хүннү
 - Б. Жужан
 - В. Түрэг
 - Г. Уйгур
 - Д. Хидан
7. Манжуудтай хамгийн анх харьцаж ирсэн Монголчууд хэн байв?
- А. Харчин
 - Б. Цахар
 - В. Баарин
 - Г. Жалайр
 - Д. Хорчин
8. Монголчууд Манжийн эрхшээлд орсон нь дараах шалтгаантай.
- А. Засаглалын хэлбэр буруу байсан.
 - Б. Ноёдын хувийн эрх ашиг байсан
 - В. Төвөөс зугатах хүч үйлчилж байсан.
 - Г. Ноёд хоорондоо хагаралтай
 - Д. Бүгд зөв
9. Богд хаант Монгол улс хэдэн яамтай байсан бэ?
- А. 6
 - Б. 5
 - В. 4
 - Г. 3
 - Д. 7
10. Монгол улс НҮБ-д хэдэн онд элссэн бэ?
- А. 1945
 - Б. 1956
 - В. 1961
 - Г. 1971
 - Д. 1992

2-Р ХЭСЭГ. ШАШИН, СОЁЛЫН АСУУЛТ (ТЕСТЭД ЭЗЛЭХ ХУВЬ 20)

1. Одоогоор олдоод буй монгол бичгийн анхны дурсгал аль нь вэ?
- А. Дуутын хадны бичиг
 - Б. Чингисийн чулууны бичиг
 - В. Бугатын гэрэлт хөшөө
 - Г. Хүйс толгойн бичээс
 - Д. Мөнх хааны гэрэлт хөшөө

2. ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын өв аль нь БИШ вэ?

- А. Дайралцаа үг
- Б. Монгол тууль
- В. Монгол данжуур
- Г. Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл
- Д. Ботго авахуулах зан үйл

3. Таван саваагүй гэж юу вэ?

- А. Алунгоо эхийн таван хүүхэд
- Б. Таван хошуу мал
- В. Гоо сайхан, эрүүл ахуйн хэрэгсэл
- Г. Хүн таван од
- Д. Оновчтой хариулт алга

4. Төрийн их баяр наадамд шагай харвааны зурхайнаас хасаа хүртэл ямар зайд сум тавьдаг вэ?

- А. 3 метр 57 см
- Б. 3 метр 75 см
- В. 4 метр 22 см
- Г. 4 метр 57 см
- Д. 4 метр 72 см

5. Бурханы шашны уламжлалуудаас Монголд хамгийн өргөн дэлгэрсэн нь аль вэ?

- А. Теравада буюу бага хөлгөн
- Б. Махаяна буюу их хөлгөн
- В. Зэн буддизм
- Г. Бүгд жигд тархсан байдаг
- Д. Оновчтой хариулт алга

6. Сансрын хүрд /орчлонгийн хүрд/-ний төв хэсэгт байдаг 3 амьтныг нэрлэнэ үү.

- А. Луу, бар, заан
- Б. Туулай, шувуу, сармагчин
- В. Тахиа, могой, гахай
- Г. Хангарди, арслан, бар
- Д. Бар, могой, луу

7. 1918 оны тооллогоор Ар Монголд хэдэн хүрээ хийд байсан бэ?

- А. 200 хүртэл
- Б. 201 - 300 орчим
- В. 301 - 400 орчим
- Г. 401 – 500 орчим
- Д. 601 - ээс дээш

8. “Энэрэн нигүүлсэхүй”-н гэгддэг шүтээн аль нь вэ?

- А. Балданлхам буюу Цогт охин тэнгэр
- Б. Манзушри буюу Зөөлөн эгшигт
- В. Жанрайсиг буюу Мэлмийгээр болгоогч
- Г. Очирваань буюу Мутартаан очирт
- Д. Майдар

9. Дараах ойлголтуудаас зөвийг сонгож дугуйлна уу.

- А. Монгол улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
- Б. Монгол улсад шашин нь төрөө хүндэтгэж, төр нь шашнаа дээдэлнэ.
- В. Монгол улсад төр, шашин хоёр ижил эрх мэдэлтэйгээр оршино.

- Г. Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухайд зохицуулалт байхгүй.
Д. Дээрх тодорхойлолт бүгд буруу.
10. _____ - г бүтээхдээ эхлээд зотон даавуун дээр амьтны гаралтай цавуу болон тусгай ургамлын шүүстэй хольж найруулсан бэлдмэлээр суурь тавина.
- А. Цаасан шуумал
 - Б. Танка буюу шүтээн зураг
 - В. Зээгт наамал
 - Г. Модон бар
 - Д. Төмөр бар

3-Р ХЭСЭГ. ГАЗАРЗҮЙ, УРГАМАЛ, АМЬТАН, ГЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН АСУУЛТ (ТЕСТЭД ЭЗЛЭХ ХУВЬ 20)

1. Хэдэн онд Монгол улсад палеонтологийн анхны судалгаа явуулсан бэ?
 - А. 1920
 - Б. 1922
 - В. 1923
 - Г. 1924
 - Д. 1925
2. 99-84 сая жилийн өмнөх цаг үе нь формацид хамаарна.
 - А. Баянширээ
 - Б. Жодохт
 - В. Нэмэгт
 - Г. Хөх тээг
 - Д. Аль нь ч биш
3. Улалзах цонж гэдэг нь-ийн олдворт газрын нэр юм?
 - А. Баянзаг
 - Б. Цагаан суварга
 - В. Сайхан овоо
 - Г. Шар цав
 - Д. Хэрмэн цав
4. Монгол орны цэнгэг усны нөөцийн 75% нь хаана агуулагдаж байна вэ?
 - А. Гүний усанд
 - Б. Гол мөрөнд
 - В. Нууранд
 - Г. Мөс хэлбэрээр
 - Д. Цэвдэг хэлбэрээр
5. Монгол орны умард болон төв буюу уулархаг хэсгээр тархсан, экологид маш чухал ач холбогдолтой, газрын гүнд байдаг, өвс, ургамал ургах нь мөн түүнээс хамаарч байдаг. Газрын гүнд байх хортой хийг газрын гадарга дээр гарахаас хамгаалдаг. Энэ юу вэ?
 - А. Газрын доор байрлах гүний ус.
 - Б. Хүрэн хөрс.
 - В. Мөнх цэвдэг
 - Г. Уулын чулуулаг.
 - Д. Бүгд зөв
6. Туул, Хараа, Ерөө, Орхон, Эгийн голууд аль ай савд хамаарах вэ?
 - А. Аль ч ай савд хамаардаггүй.
 - Б. Номхон далайн ай
 - В. Төв Азийг гадагш урсгалгүй ай сав.

- Г. Хойд мөсөн далай
- Д. Аль алинд нь хамаарах голууд байна.
- 7. Монгол улсын хамгийн өндөрлөгт орших аймгийн төвийг сонгоно уу.
 - А. Зуунмод
 - Б. Даланзадгад
 - В. Өлгий
 - Г. Алтай
 - Д. Ховд
- 8. Монгол орны физик газарзүйг тодорхойлбол:
 - А. Далайгаас алслагдсан, хуурай уур амьсгалтай
 - Б. Өндөрлөг учраас салхи их салхилдаг.
 - В. Тал, хээр, говь, цөл, өндөр уулын, ойн бүс гэх мэт байгалийн олон бүс бүслүүртэй
 - Г. Гадаргын усны нөөц харьцангуй багатай
 - Д. Бүгд зөв
- 9. Монгол орны хамгийн том гүрвэлийг нэрлэнэ үү?
 - А. Замба гүрвэл
 - Б. Говийн гүрвэл
 - В. Цоохор хонин гүрвэл
 - Г. Төмөр гүрвэл
 - Д. Аль нь ч биш
- 10. Говьд ой үүсгэдэг модыг нэрлэнэ үү?
 - А. Заг
 - Б. Хайлаас
 - В. Сухай
 - Г. Улиангар
 - Д. Сондуул

4-Р ХЭСЭГ. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН АСУУЛТ (ТЕСТЭД ЭЗЛЭХ ХУВЬ 20)

- 1. Монгол Улсын ерөнхийлөгч хэдэн жилийн хугацаатай сонгогддог вэ?
 - А. 4 жил
 - Б. 6 жил
 - В. 7 жил
 - Г. 5 жил
 - Д. 2 жил
- 2. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллагыг сонгоно уу.
 - А. Монгол улсын засгийн газар
 - Б. Монгол улсын их хурал
 - В. Монгол улсын ерөнхийлөгч
 - Г. Монгол ардын нам
 - Д. Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- 3. Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн хэдэн ам.доллар вэ? /2023 оны байдлаар/
 - А. 3000 ам.доллар орчим
 - Б. 5000 ам.доллар орчим
 - В. 6000 ам.доллар орчим
 - Г. 8000 ам.доллар орчим

- Д. 8500 ам.доллар орчим
4. 2023 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт хэдэн хувьтай байсан бэ?
 - А. 11 хувь
 - Б. 10 хувь
 - В. 8 хувь
 - Г. 7 хувь
 - Д. 5 хувь
 5. 2023 онд Монгол улсад инфляцийн түвшин хэдэн хувьтай байсан бэ?
 - А. 9.9 хувь
 - Б. 7.9 хувь
 - В. 8.9 хувь
 - Г. 6.9 хувь
 - Д. 10 хувь
 6. Монгол Улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хэдэн төгрөг вэ?
 - А. 500.000₮
 - Б. 550.000₮
 - В. 600.000₮
 - Г. 660.000₮
 - Д. 700.000₮
 7. Монгол Улсад нийгмийн даатгалд даатгуулагчид цалин хөлснөөсөө хэдэн хувийг нийгмийн даатгалын санд төлдөг вэ?
 - А. 20-22 хувь
 - Б. 22-24 хувь
 - В. 24-26 хувь
 - Г. 26-28 хувь
 - Д. 25-27 хувь
 8. Монгол улс Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад ямар үүрэгтэй вэ?
 - А. Гишүүн
 - Б. Огт хамааралгүй
 - В. Дэмжигч гишүүн
 - Г. Ажиглагч гишүүн
 - Д. Жинхэнэ гишүүн
 9. Монгол улсын иргэн гэр бүлийн хэрэгцээнд нийслэл орчимд ямар хэмжээний газар өмчлөх эрхтэй вэ?
 - А. 0.07га хүртэл газар
 - Б. 0.7га хүртэл газар
 - В. 0.77га хүртэл газар
 - Г. 1га хүртэл газар
 - Д. 1.7га хүртэл газар
 10. Монгол улсын экспортын голлох бүтээгдэхүүн аль нь вэ?
 - А. Алт
 - Б. Зэс
 - В. Газрын тос
 - Г. Нүүрс
 - Д. Угаасан ноолуур

5-Р ХЭСЭГ. САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ АСУУЛТ (ТЕСТЭД ЭЗЛЭХ ХУВЬ 20)

1. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, ангилал зэрэглэл тогтоох шалгалт 1 жилд хэдэн удаа зохион байгуулагдах вэ?
 - А. 1 жилд 1 удаа
 - Б. 1 жилд 3 удаа
 - В. 1 жилд 2 удаа
 - Г. 1 жилд 4 удаа
 - Д. Дээрх бүгд буруу
2. Жуулчны хөтөч тайлбарлагчийн үнэмлэх авах, ангилал зэрэглэл тогтоолгох хүсэлтэд ямар материал бүрдүүлэх вэ?
 - А. Өнгөт гэрэл зураг 2 хувь
 - Б. Эрүүл мэндийн тодорхойлолт
 - В. Иргэний үнэмлэх
 - Г. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан гэрчилгээ
 - Д. Дээрх бүгд зөв
3. Аялал жуулчлал гэж юуг хэлэх вэ? /Аялал жуулчлалын тухай хуульд зааснаар/
 - А. хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялан явахыг
 - Б. хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор аялан явахыг
 - В. хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 30 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялан явахыг
 - Г. хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 30 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор аялан явахыг
 - Д. хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 45 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор аялан явахыг
4. Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан нийтийн эрхзүйн хуулийн этгээдийн нэр
 - А. Аялал жуулчлалын холбоо
 - Б. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо
 - В. Мэргэжлийн аялал жуулчлалын холбоо
 - Г. Аяллын холбоо
 - Д. Нийтийн аялал жуулчлалын холбоо
5. Ур чадвар болон ерөнхий мэдлэгийн шалгалтад нийлбэр дүн хэд байхад оролцогчийг шалгалтад тэнцсэнд тооцох вэ?
 - А. 60 ба түүнээс дээш
 - Б. 70 ба түүнээс дээш
 - В. 75 ба түүнээс дээш
 - Г. 80 ба түүнээс дээш
 - Д. 65 ба түүнээс дээш
6. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, ангилал зэрэглэл тогтоох шалгалтын хураамжийг хэн батлах вэ?
 - А. Байгаль орчин, аялал жуулчлалын яам
 - Б. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
 - В. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл
 - Г. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн дарга
 - Д. Хөтөч тайлбарлагчдын холбоо
7. Аялал жуулчлалын салбар монгол улсын засгийн газрын аль яаманд харъяалагдаж байгаа вэ?
 - А. Аялал жуулчлалын яам

- Б. Байгаль орчин, аялал жуулчлалын яам
 - В. Зам тээврийн яам
 - Г. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
 - Д. Дэд бүтцийн яам
8. Аялал жуулчлалын тухай хууль шинэчлэн найруулагдаж хэдэн онд батлагдсан бэ?
- А. 2020 онд
 - Б. 2024 онд
 - В. 2023 онд
 - Г. 2019 онд
 - Д. Дээрх бүгд буруу
9. Аяллын агентийн зөв тодорхойлолтыг сонгоно уу.
- А. Аяллын агент гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулж байгаа хуулийн этгээдийг хэлнэ
 - Б. Аяллын агент гэж жуулчдыг нутгийн иргэдтэй холбон уулзуулж байгаа хуулийн этгээдийг хэлнэ
 - В. Аяллын агент гэж дор хаяж 10 жил үйл ажиллагаа явуулсан тур операторыг хэлнэ
 - Г. Аяллын агент гэж нисэх онгоцны тийз борлуулдаг хуулийн этгээдийг хэлнэ
 - Д. Дээрх бүгд буруу
10. "Тусгай сонирхлын аялал жуулчлал" гэж _____ хэлнэ.
- А. Монгол орноор аялахыг
 - Б. Бартаатай замаар давхихыг
 - В. Тусгай мэргэжлийн ур чадвар, техник шаардсан аялал жуулчлалыг
 - Г. Улаанбаатар хотоор аялахыг
 - Д. Дээрх бүгд зөв

ХАРИУЛТ

1-Р ХЭСЭГ. ТҮҮХ, АРХЕОЛОГИ

1б, 2а, 3г, 4б, 5а, 6в, 7д, 8д, 9б, 10в

2-Р ХЭСЭГ. ШАШИН, СОЁЛ

1б, 2а, 3в, 4д, 5б, 6в, 7д, 8в, 9а, 10б

3-Р ХЭСЭГ. ГАЗАРЗҮЙ, УРГАМАЛ, АМЬТАН, ГЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИ

1б, 2а, 3а, 4в, 5в, 6г, 7г, 8д, 9а, 10а

4-Р ХЭСЭГ. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨР

1б, 2б, 3в, 4г, 5б, 6г, 7в, 8г, 9а, 10г

5-Р ХЭСЭГ. САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1в, 2д, 3а, 4б, 5б, 6в, 7г, 8в, 9а, 10в